

“ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС” ХК

2022 оны 05 дугаар сарын 15-ны өдөр

№ТУЗТ 09/2022

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Нийтэд санал болгох энгийн хувьцааны
үнэ тогтоох тухай

Компанийн тухай хуулийн 43 дугаар зүйл, 55 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.6, “Эрдэнэс сольюшинс ХК (“Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.10.7 дахь хэсэг, хөрөнгийн үнэлгээний “Мөнх-Оргил трейд” ХХК нь тус Компанийг 22,615,200,000 (хорин хоёр тэрбум зургаан зуун арван таван сая хоёр зуун мянга) төгрөгөөр буюу 1 (нэг) ширхэг хувьцааг 143.25 (нэг зуун дөчин гурван төгрөг хорин таван мөнгө) төгрөгөөр үнэлсэн, Компанийн хувьцаа эзэмшигчидийн 2022 оны 05-р сарын 14-ний өдрийн ээлжит бус хурлын шийдвэр, зах зээл дээр нэмж гаргаж буй энгийн хувьцааны үнэ тогтоох талаар андеррайтерын “Гүүд сек ҮЦК” ХХК-тай зөвшилцсөний дагуу, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн эргэлтэд гаргаж буй нийт 18,521,598 (арван найман сая таван зуун хорин нэгэн мянга таван зуун ерэн найм) хүртэлх ширхэг нийтэд санал болгож буй энгийн хувьцааны нэг ширхэг бүрийн үнийг 108 (нэг зуун найм) төгрөгөөр тогтоож, нийтэд тогтоосон үнийн аргаар санал болгосугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 05-р сарын 14-ны өдрийн ээлжит бус хурлаар компанийн нэмж хувьцаа гаргахыг шийдвэрлэсэнтэй холбогдуулан Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12-р сарын 13-ны өдрийн №ТУЗТ 11/2021 тоот тогтоолын 2, 3,4,5 –р заалтууд болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 01-р сарын 31-ний өдрийн №ТУЗТ 02/2022 тогтоол, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 03-р сарын 01-ний өдрийн №ТУЗТ 04/2022 тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/Т.ЗОЛБОО/